



Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2023 оны 2 дүгээр улирлын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн товч танилцуулга

199 байгууллага нь 2023 оны 2 дугаар улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 14801 мэдээлэл байршуулах ёстойгоос 93,1% буюу 13776 мэдээллийг хуулийн хугацаанд, 2,4% буюу 354 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 4,5% буюу 671 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 93,1 хувьтай гарлаа.



Диаграмм 1. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт


Мэдээлэл хугацаандаа байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Диаграмм 2. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт

Мэдээлэл байршуулалтыг байгууллагын төрлөөр нь ангилан харуулбал:

Төсвийн 1 байгууллага 2 дугаар улирлын байдлаар 75 мэдээлэл байршуулах ёстой ба 165 байгууллага нийтдээ 12375 мэдээлэл байршуулах ёстойгоос 11673 мэдээллийг хуулийн хугацаанд, 251 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 38 байгууллага 451 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 94,4 хувьтай гарлаа.



Диаграмм 3. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт

Төрийн сан 2 дугаар улирлын байдлаар 1 байгууллага 84 мэдээлэл, 20 төрийн сан нийтдээ 1680 мэдээлэл байршуулахаас 1474 мэдээллийг хуулийн хугацаанд, 73 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 133 мэдээллийг огт байршуулаагүй ба мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 87.7 хувьтай байна.



Диаграмм 4 Төрийн сангуудын мэдээлэл байршуулалт

Орон нутгийн өмчит 15 байгууллага нь нийт 671 мэдээлэл байршуулахаас 629 мэдээллийг хуулийн хугацаанд, 30 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан

ба 12 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 93,7 хувьтай гарлаа.



Диаграмм 5. Орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээлэл байршуулал

Энэ удаагийн шалгалтаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 93,1 хувь, хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 66,1 хувь, шилэн дансны шинэ цахим системийн бүртгэлжүүлэлт 99 хувьтай байна. Шинэ нэгдсэн цахим системд бүртгүүлээгүй Нарийнтээл сумын Соёлын төв болон Өв Эко мийт ОНӨҮГазар бүртгүүлэх шаардлагатай байна.

Төсвийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансанд байршуулах мэдээллээ бүрэн сонгож өгөөгүйн улмаас мэдээлэл огт байршуулаагүй харагдаж байгаа тул байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл болон оруулах мэдээллээ бүрэн гүйцэд сонгож оруулах хэрэгтэй. 1 дүгээр улирлын шалгалтаар илэрсэн зөрчил дахин давтагдаж, мэдээллээ нэмж оруулаагүйн улмаас байршуулаагүй мэдээллийн тоо өссөн мөн 56 төсвийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд улирлын мэдээг огт илгээгээгүй байгаа нь байгууллагууд хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээхдээ анхаарах шаардлагатай байна.

“Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасны дагуу байгууллагууд 19,445,119,855 (арван есөн тэрбум дөрвөн зуун дөчин таван сая нэг зуун арван есөн мянга найман зуун тавин тав) төгрөгийг мэдээллийг дутуу байршуулсан байна. Ийм байгууллагууд төрийн сангийн хуулгаар гарч буй ажил гүйлгээг шилэн дансанд бүрэн мэдээлэх

шаардлагатай. Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлогын гүйлгээг 2 дугаар улирлын байдлаар 17,087,876,237 (арван долоон тэрбум наян долоон сая найман зуун далан зургаан мянга хоёр зуун гучин долоо) төгрөгийг дутуу байршуулсан байгаа нь төрийн сангийн хуулгаар орж буй орлогын гүйлгээг шилэн дансанд үнэн зөв, бүрэн мэдээлэх шаардлагатай байна.

Шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд гарч байгаа зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал мөн удирдлагын болон дотоод хяналтын хяналтууд байхгүйгээс хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн гүйцэд байршуулахгүй байгаа тул цаашид төсвийн шууд захирагч нар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үүнд дотоод хяналтын нэгжийг татан оролцуулах, мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн ажлын хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаг болох, мэдээлэл байршуулж байгаа албан хаагчид шилэн дансны цахим хуудсанд ымэдээлэл байршуулахдаа мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв байршуулах, мэдээлэл хоорондын уялдааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв хуулийн хугацаанд байршуулж байгаа эсэхэд улиралд нэгээс доошгүй удаа хяналт тавих;

2. Шинэ нэгдсэн цахим системд бүртгэлгүй байгаа Нарийнтээл сум Соёлын төв, Өв.Эко мийт ОНӨҮГазрыг бүртгүүлэх, мэдээллээ бүрэн гүйцэд байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;

3. Байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл болон заавал оруулах мэдээллээ бүрэн гүйцэд сонгож оруулах;

4. Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлогын гүйлгээг төрийн сангийн хуулгын дагуу бүрэн гүйцэт, үнэн зөв, тухай бүры оруулж хэвших;

5. Шилэн дансны шинэ цахим системийн тухай сургалт, сурталчилгааг аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээг авах;

6. Өгсөн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах;